



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

ХҮН АМЫН АМЬДАРЧ БУЙ ОРЧИН НӨХЦӨЛ 2025

2026 он



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ-2025

Улаанбаатар хот
2026 он



ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

Б.Шинэцэцэг

Ахлах мэргэжилтэн

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Г.Чинжаргал

Хэлтсийн дарга

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг
27-р хороо, Замчдын гудамж-3
Засаг даргын Тамгын газрын байр 112, 114 тоот
Утас: 11-301637, 70122688
Цахим хаяг: bayangol@nso.mn
Цахим хуудас: <http://www.1212.mn>
<http://www.ubstat.mn>
<http://www.bgd.mn>



АГУУЛГА

НЭГ. НУТАГ ДЭВСГЭР, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ.....	8
ХОЁР. ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ, СУУЦНЫ НӨХЦӨЛ.....	12
ГУРАВ. АРГА, АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР.....	16

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1.НУТАГ ДЭВСГЭР, ХҮН АМЫН НЯГТРАЛ, хороогоор, жил бүрийн эцэст.....	9
ХҮСНЭГТ 2.ӨРХИЙН ТОО, хороогоор, жил бүрийн эцэст.....	10
ХҮСНЭГТ 3.ӨРХИЙН ТОО, сууцны төрлөөр, жил бүрийн эцэст.....	13
ХҮСНЭГТ 4.ГЭР ХОРООЛЛОЛД АМЬДАРДАГ ӨРХ, ХҮН АМ, хороогоор, 2025 оны жилийн эцэст..	14
ХҮСНЭГТ 5.БАЙШИН ХОРООЛЛОЛД АМЬДАРДАГ ӨРХ, ХҮН АМ, хороогоор, 2025 оны жилийн эцэст.....	15

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1.ХҮН АМЫН ТОО, 1 га нутаг дэвсгэрт ногдох хүн амын нягтрал, жил бүрийн эцэст.....	8
ЗУРАГ 2.ӨРХИЙН ТОО, жилийн дундаж өсөлтийн хувь, жил бүрийн эцэст.....	11
ЗУРАГ 3.ДҮҮРГИЙН ӨРХИЙН ТОО, ДУНДАЖ АМ БҮЛ, мянган өрхөөр, жил бүрийн эцэст.....	12
ЗУРАГ 4.ӨРХИЙН ТОО, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2025 оны жилийн эцэст	12
ЗУРАГ 5.ӨРХИЙН ТОО, ам бүлийн тоо, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2025 оны жилийн эцэст.....	13
ЗУРАГ 6.ДҮҮРГИЙН ӨРХ, хорооллоор, дүнд эзлэх хувь, 2025 оны жилийн эцэст.....	14



НУТАГ ДЭВСГЭР, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ

Дүүргийн хүн амын нягтрал өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар буурсан байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 79 дүгээр зарлигаар Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын харьяа Ажилчин, Найрамдал, Амгалан, Зүүн Сэлбэ, Сүхбаатар, Хоршоолол, Чингэлтэй, Толгойт, Октябрь, Төмөр замын хороодыг татан буулгаж, Сүхбаатар, Октябрь, Ажилчин, Найрамдал гэх 4 раойныг байгуулсан байна. Баянгол дүүрэг нь 1965 онд Октябрын район нэртэйгээр байгуулагдсан. Нийслэл хотод Сүхбаатар, Октябрь, Найрамдал, Ажилчин гэсэн район бий болсноор нийслэл Улаанбаатар хотын засаг захиргааны үндсэн нэгж болох район түүний дотор Баянгол дүүргийн үүсэл, хөгжлийн түүх эхэлсэн билээ.

Улмаар Монгол Улсад ардчилал, шинэчлэл өрнөсөн 1990 оны эхээр Улаанбаатар хотын дүүргүүдийн засаг, захиргааны байгууллагуудын ажлын ачааллыг жигдлэх,

үйлдвэрлэл, үйлчилгээний хэт төвлөрлийг сааруулах зорилгоор УИХ-ын 1992 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн "Улаанбаатар хотын район, хороог татан буулгах, шинээр байгуулах тухай" 18 тоот тогтоол гарч Октябрийн районуыг хоёр хуваан Баянгол, Сонгинорхайрхан дүүрэг болгон шинээр зохион байгуулагдаж байсан түүхтэй.

Баянгол дүүрэг 2949 га газар нутагтай, Монголын бурхан шашинтны төв Гандантэгчинлин хийд, Өргөө кино театр, Улаанбаатар палас, МҮОНРТ, UBS телевиз, Төмөр замын дуу бүжгийн чуулга, МҮЭСТО зэрэг соёл, урлаг, түүх дурсгалын төвүүд байгаагаас гадна Рамада зочид буудал, Макс худалдааны төв, Барс, Хархорин, Гурвалжин зах, Сандэй плаза зэрэг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний томоохон зах, төвүүд олноор үйл ажиллагаа явуулж байдаг онцлогтой.

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ТОО, 1 га нутаг дэвсгэрт ногдох хүн амын нягтрал, жил бүрийн эцэст



Дүүргийн хүн ам, өрхийн тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж хороодын иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжид ачаалалтай байгаа тул төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор өрх, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, барилгажилт, дахин төлөвлөлт зэргийг харгалзан Нийслэлийн Баянгол дүүргийн

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 04/03 тоот тогтоолоор 3, 4, 5, 6, 7, 8, 11, 12, 17, 18, 20, 23, 25 дугаар хороодын хилийн цэсийг шинэчлэн тогтоож 26, 27, 28, 29, 30, 31, 32, 33, 34 дүгээр хороодыг шинээр байгуулан нийт 34 хороотойгоор төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна.

Тус дүүрэг нь 34 хороо, 71.8 мянган өрхийн 254.7 мянган хүн амтай хотын төвд оршдог томоохон дүүргийн нэг юм.

Нийслэлийн хүн амын 95.6 хувь нь төвийн 6 дүүрэгтээ амьдарч байгаагийн 15.2 хувь нь тус дүүрэгт амьдарч байна. Тус дүүрэг нь газар нутгийн хэмжээгээрээ нийслэлийн хэмжээнд

хамгийн бага буюу 0.6 хувийг эзэлдэг боловч хүн амын тоогоор 4 дүгээрт эрэмбэлэгдэж, нягтралаараа хамгийн өндөрт ордог дүүрэг юм. 2013 оноос тасралтгүй хүн амын нягтрал өсөн нэмэгдэж байсан боловч 2025 онд 2 хүнээр буурсан байна.

ХҮСНЭГТ 1. НУТАГ ДЭВСГЭР, ХҮН АМЫН НЯГТРАЛ, хороогоор, жил бүрийн эцэст

Хороо	2018	2019	2020*	2021*	2022**	2023	2024	2025
	1 га талбайд ногдох хүний тоо							
Дүн	77	76	79	80	84	86	88	86
I хороо	178	172	385	399	395	399	398	372
II хороо	256	266	271	280	284	281	290	286
III хороо	149	151	157	166	153	164	170	171
IV хороо	120	127	252	249	389	362	371	364
V хороо	267	285	301	305	322	302	299	281
VI хороо	306	300	301	300	324	315	313	294
VII хороо	360	356	350	335	373	448	459	447
VIII хороо	392	389	393	401	379	385	396	392
IX хороо	135	128	130	130	157	160	168	162
X хороо	118	105	106	110	108	104	104	102
XI хороо	72	72	71	71	77	79	80	79
XII хороо	588	567	586	577	538	526	520	512
XIII хороо	252	252	270	276	282	254	259	269
XIV хороо	311	288	309	321	327	316	306	292
XV хороо	308	303	309	303	322	301	311	329
XVI хороо	119	103	104	101	97	90	89	84
XVII хороо	486	501	500	532	718	675	670	626
XVIII хороо	391	372	378	384	377	417	434	420
XIX хороо	245	232	230	284	299	306	314	308
XX хороо	7	8	9	8	4	4	4	3
XXI хороо	87	94	95	93	89	79	76	74
XXII хороо	76	73	75	74	73	69	68	66
XXIII хороо	80	73	80	78	83	77	76	72
XXIV хороо	-	-	87	102	126	182	202	210
XXV хороо	-	-	91	96	60	63	65	63
XXVI хороо	-	-	-	-	226	263	290	287
XXVII хороо	-	-	-	-	173	166	182	184
XXVIII хороо	-	-	-	-	565	546	546	538
XXIX хороо	-	-	-	-	25	29	30	33
XXX хороо	-	-	-	-	308	291	302	285
XXXI хороо	-	-	-	-	301	366	383	385
XXXII хороо	-	-	-	-	451	499	515	511
XXXIII хороо	-	-	-	-	425	426	434	411
XXXIV хороо	-	-	-	-	559	540	562	557

*- 2020 оноос 1 дүгээр хорооноос 24, 4 дүгээр хорооноос 25 дугаар хороо тус тус шинээр хороо байгуулагдсан.

** - 2022 онд шинээр 9 хороо нэмэгдсэн.

2001 онд дүүргийн 1 га нутаг дэвсгэрт 48.8 буюу 1 км² нутаг дэвсгэрт 4876 хүн оршин сууж байсан бол жилээс жилд хүн амын нягтрал нэмэгдсээр 2020 онд 1 га нутаг дэвсгэрт 78.5 буюу 1 км² нутаг дэвсгэрт 7851 хүн, 2021 онд 1 га нутаг дэвсгэрт 80.2 буюу 1 км² нутаг дэвсгэрт 8016 хүн, 2022 онд 1 га нутаг дэвсгэрт 83.7 буюу

1 км² нутаг дэвсгэрт 8372 хүн, 2023 онд 1 га нутаг дэвсгэрт 85.8 буюу 1 км² нутаг дэвсгэрт 8578 хүн, 2024 онд 1 га нутаг дэвсгэрт 88.0 буюу 1 км² нутаг дэвсгэрт 8797 хүн, 2025 онд 1 га нутаг дэвсгэрт 86.4 буюу 1 км² нутаг дэвсгэрт 8637 хүн тус тус оршин сууж байна.

ХҮСНЭГТ 2. ӨРХИЙН ТОО, хороогоор, жил бүрийн эцэст


Хороо	2020	2021	2022	2023	2024	2025	2025 2024	
	тоо						дүн	хувь
Дүүргийн дүн	63 079	62 784	65 543	69 519	71 371	71 792	421	0.6
I хороо	2 710	2 708	2 704	2 746	2 755	2 638	-117	-4.2
II хороо	2 425	2 449	2 463	2 532	2 613	2 612	-1	0.0
III хороо	4 660	4 670	1 634	1 889	1 979	2 030	51	2.6
IV хороо	3 502	3 449	2 038	1 955	1 963	1 923	-40	-2.0
V хороо	3 294	3 342	2 476	2 404	2 344	2 309	-35	-1.5
VI хороо	4 602	4 441	3 071	3 151	3 112	3 037	-75	-2.4
VII хороо	3 332	3 032	1 602	1 762	1 826	1 809	-17	-0.9
VIII хороо	3 319	3 130	1 919	2 067	2 116	2 148	32	1.5
IX хороо	1 915	1 851	2 280	2 404	2 521	2 556	35	1.4
X хороо	2 076	2 066	2 044	2 117	2 113	2 103	-10	-0.5
XI хороо	1 795	1 737	1 536	1 634	1 659	1 733	74	4.5
XII хороо	2 852	2 792	1 521	1 558	1 553	1 542	-11	-0.7
XIII хороо	1 143	1 147	1 191	1 173	1 192	1 195	3	0.3
XIV хороо	1 073	1 076	1 108	1 142	1 150	1 157	7	0.6
XV хороо	1 147	1 139	1 151	1 170	1 199	1 210	11	0.9
XVI хороо	1 646	1 589	1 514	1 526	1 516	1 469	-47	-3.1
XVII хороо	2 889	2 868	2 195	2 207	2 207	2 167	-40	-1.8
XVIII хороо	2 993	3 006	2 264	2 554	2 702	2 694	-8	-0.3
XIX хороо	1 538	1 776	1 801	1 847	1 888	1 909	21	1.1
XX хороо	2 984	3 050	1 136	1 086	1 033	984	-49	-4.7
XXI хороо	2 367	2 323	2 203	2 040	1 988	2 052	64	3.2
XXII хороо	2 200	2 216	2 128	2 044	1 925	1 888	-37	-1.9
XXIII хороо	1 446	1 394	1 581	1 613	1 637	1 679	42	2.6
XXIV хороо	2 040	2 326	2 719	4 016	4 435	4 699	264	6.0
XXV хороо	3 131	3 207	1 991	2 119	2 134	2 109	-25	-1.2
XXVI хороо	-	-	3 762	4 494	4 977	5 147	170	3.4
XXVII хороо	-	-	1 383	1 397	1 493	1 489	-4	-0.3
XXVIII хороо	-	-	2 042	2 089	2 092	2 039	-53	-2.5
XXIX хороо	-	-	2 146	2 407	2 484	2 725	241	9.7
XXX хороо	-	-	1 773	1 740	1 843	1 767	-76	-4.1
XXXI хороо	-	-	1 308	1 634	1 726	1 846	120	7.0
XXXII хороо	-	-	1 697	1 852	1 957	1 988	31	1.6
XXXIII хороо	-	-	1 930	1 931	1 964	1 918	-46	-2.3
XXXIV хороо	-	-	1 232	1 219	1 275	1 221	-54	-4.2

Дүүргийн хувьд хүн амын нягтрал хамгийн өндөртэй 17 дугаар хороонд 1 га нутаг дэвсгэрт 627 хүн ногдож байгаа бол хамгийн бага буюу хүн амын нягтрал сийрэгтэй хороо нь 20 дугаар хороо байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар тус дүүрэгт 71792 өрхөд 254710 хүн буюу нийслэлийн нийт өрхийн 14.6 хувь, улсын нийт өрхийн 7.1 хувь нь амьдарч байна. Тус дүүргийн хэмжээнд 2500-

аас дээш өрхтэй 7 хороо байгаагаас 26 дугаар хороонд хамгийн олон өрх буюу 5147 өрх, 20 дүгээр хороонд хамгийн бага буюу 984 өрх оршин сууж байна.

ЗУРАГ 2. ӨРХИЙН ТОО, ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТИЙН ХУВЬ, ЖИЛ БҮРИЙН ЭЦЭСТ



Нийт өрхийн тоо 2017 оноос 13036 (22.2%) өрхөөр өссөн бол өмнөх оноос 421 (0.6%) өрхөөр буурсан үзүүлэлттэй байна.

Өрхийн жилийн дундаж өсөлтийн хурдыг сүүлийн 9 жилийн байдлаар авч үзвэл 2014 онд 5.6 хувь, 2015 онд 4.2 хувь, 2016 онд 0.4 хувь, 2017 онд 0.9 хувь, 2018 онд 1.3 хувь, 2020 онд 0.2

хувь, 2022 онд 4.2 хувь, 2023 онд 6.1 хувиар, 2024 онд 2.7 хувиар, 2025 онд 0.6 хувиар тус тус өссөн байна. Харин 2021 онд 0.5 хувиар буурчээ. 2014 онд өрхийн дундаж өсөлтийн хурд хамгийн их байсан бол 2020 онд хамгийн бага буюу 0.2 хувь байна.




ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ, СУУЦНЫ НӨХЦӨЛ

Дүүргийн өрхийн тоо өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар өссөн байна.

Өрхийг илэрхийлэх өөр нэг үзүүлэлт нь 1 өрхөд ногдох хүний тоо юм. Нэг өрхийн дундаж ам бүлийн тоо 2011 онд 4.0 байсан бол тухайн үеэс буурсаар 2015 онд 3.5 болсон. 2014, 2017, 2018, 2021, 2022 онуудад 3.8 байсан 2016, 2020 онуудад 3.7, 2019, 2023, 2024 онуудад 3.6 хүн ногдож байна.

Нийслэл хотын дүнгээр авч үзвэл нэг өрхийн дундаж ам бүлийн тоо Налайх дүүрэгт их буюу 3.7 хүн, Багануур дүүрэгт хамгийн цөөн буюу 3.3 хүн, бусад дүүрэгт 3.4-3.6 хүн байна.

ЗУРАГ 3. ДҮҮРГИЙН ӨРХИЙН ТОО, ДУНДАЖ АМ БҮЛ, мянган өрхөөр, жил бүрийн эцэст



ЗУРАГ 4. ӨРХИЙН ТОО, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2025 оны жилийн эцэст

■ эмэгтэй
■ эрэгтэй




Монгол Улсын өрхийн ам бүлийн бүтэц нь хүн амын өсөлттэй уялдан өөрчлөгдсөөр ирсэн байна.

Нийт өрхийн 47.3 хувь нь эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй, 52.7 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна.

Дүүргийн нийт өрхийн 17.2 хувь нь 2 ам бүлтэй өрх, 17.5 хувь нь 3 ам бүлтэй өрх, 19.7 хувь нь 4 ам бүлтэй өрх, 14.9 хувь нь 5 ам бүлтэй өрх, 8.3 хувь нь 6 ам бүлтэй өрх, 3.4 хувь нь 7 ам бүлтэй өрх, 1.6 хувь нь 8 ам бүлтэй өрх, 0.9 хувь нь 9 ам бүлтэй өрх, 0.9 хувь нь 10-аас дээш ам бүлтэй өрх тус тус эзэлж байна. Харин ганц биеэр өрх үүсгэн амьдарч буй хүн 15.7 хувь байна.

ЗУРАГ 5.

ӨРХИЙН ТОО, ам бүлийн тоо, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2025 оны жилийн эцэст



Эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй нийт өрхийн 25.7 хувь нь 2 ам бүлтэй өрх буюу хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн хувьд 4 ам бүлтэй өрх хамгийн өндөр буюу 22.7 хувийг эзэлж байна. Аль ч цаг үед 3-4 ам бүлтэй өрхийн нийт өрхөд

эзлэх хувийн жин хамгийн өндөр байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар дүүргийн нийт өрхийн 86.4 хувь нь орон сууцны хороололд үлдсэн 13.6 хувь нь гэр хороололд амьдарч байна.

ХҮСНЭГТ 3.

ӨРХИЙН ТОО, сууцны төрлөөр, жил бүрийн эцэст

Сууцны төрөл		2021	2022	2023	2024	2025	2025 2024	
		тоо					дүн	хувь
Нийт өрх		62 784	65 543	69 519	71 371	71 792	421	0.6
Үүнээс:	Орон сууцны хорооллын өрхийн тоо	51 953	54 819	59 588	61 655	62 129	474	0.8
	Нийтийн орон сууц	51 532	54 369	59 234	61 370	61 852	482	0.8
	Тусдаа тохилог орон сууц	421	450	354	281	276	-5	-1.8
	Орон гэргүй	-	-	-	4	1	-3	-75.0
	Гэр хорооллын өрхийн тоо	10 831	10 724	9 931	9 716	9 663	-53	-0.5
	Тохилог орон сууц	199	86	44	63	104	41	65.1
	Байшин	5 839	5 659	5 518	5 188	5 573	385	7.4
	Монгол гэр	4 791	4 973	4 368	4 464	3 984	-480	-10.8
	Орон гэргүй	2	6	1	1	2	1	100.0
	Орон сууцны хороололд амьдарч буй өрхийн эзлэх %	82.4	82.7	83.6	85.7	86.5	-	-
	Гэр хороололд амьдарч буй өрхийн эзлэх %	17.6	17.3	16.4	14.3	13.5	-	-

Нийт өрхийн 61852 (86.2%) нь нийтийн орон сууцанд, 276 (0.4%) нь бие даасан тохилог сууцанд, 5573 (7.8%) нь сууцны тусдаа байшинд, 3984 (5.6%) нь монгол гэрт тус тус амьдарч байна.

ЗУРАГ 6. ДҮҮРГИЙН ӨРХ, хорооллоор, дүнд эзлэх хувь, жилийн бүрийн эцэст



2025 оны эцэст 3 өрхийн 3 хүн орон гэргүйн улмаас гадаа, шатны хонгил зэрэг зориулалтын бус сууцанд амьдарч байна. Жил ирэх бүр орон гэргүй, тэнэмэл иргэдийн тоо буурч байгаад 2022, 2024 онуудад өсөж, 2023 онд харин 1 болтлоо буурч байсан байна.

ХҮСНЭГТ 4. ГЭР ХОРООЛОЛД АМЬДАРДАГ ӨРХ, ХҮН АМ, хороогоор, 2025 оны жилийн эцэст

Хорооны дугаар	Гэр хорооллын									
	Өрх	Хүн ам	Тохилог орон сууц		Байшинд амьдардаг		Гэрт амьдардаг		Орон гэргүй	
			Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам
	Тоо									
Дүн	9 663	34 405	104	381	5 573	20 069	3 984	13 953	2	2
IX хороо	459	1 698	36	81	253	957	170	660	-	-
X хороо	1 566	5 965	-	-	785	3 155	781	2 810	-	-
XI хороо	746	2 815	10	51	539	1 896	197	868	-	-
XII хороо	1	4	-	-	-	-	1	4	-	-
XVI хороо	1 086	3 707	38	173	651	2 213	397	1 321	-	-
XX хороо	198	743	-	-	44	214	154	529	-	-
XXI хороо	2 052	6 606	8	33	1 288	4 073	755	2 499	1	1
XXII хороо	1 829	6 814	-	-	1 026	3 974	802	2 839	1	1
XXIII хороо	1 679	5 927	12	43	975	3 552	692	2 332	-	-
XXIV хороо	2	9	-	-	1	2	1	7	-	-
XXIX хороо	41	104	-	-	9	26	32	78	-	-
XXX хороо	1	3	-	-	1	3	-	-	-	-
XXXI хороо	3	10	-	-	1	4	2	6	-	-

Хөх-Байшин хороолол
Ногоон-Гэр хороолол

ХҮСНЭГТ 5.

БАЙШИН ХОРООЛОЛД АМЬДАРДАГ ӨРХ, ХҮН АМ, хороогоор, 2025 оны жилийн эцэст

Хорооны дугаар	Байшин хорооллын							
	Өрх	Хүн ам	Нийтийн орон сууц		Тохиллог орон сууц		Орон гэргүй	
			Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам
Дүүргийн дүн	62 129	220 305	61 852	219 358	276	946	1	1
I хороо	2 638	9 265	2 637	9 264	-	-	1	1
II хороо	2 612	9 256	2 612	9 256	-	-	-	-
III хороо	2 030	7 327	2 019	7 274	11	53	-	-
IV хороо	1 923	7 559	1 919	7 545	4	14	-	-
V хороо	2 309	7 936	2 309	7 936	-	-	-	-
VI хороо	3 037	10 027	3 033	10 015	4	12	-	-
VII хороо	1 809	7 039	1 779	6 932	30	107	-	-
VIII хороо	2 148	8 019	2 146	8 009	2	10	-	-
IX хороо	2 097	6 644	2 028	6 507	69	137	-	-
X хороо	537	1 678	537	1 678	-	-	-	-
XI хороо	987	3 506	987	3 506	-	-	-	-
XII хороо	1 541	5 308	1 541	5 308	-	-	-	-
XIII хороо	1 195	4 884	1 195	4 884	-	-	-	-
XIV хороо	1 157	4 115	1 157	4 115	-	-	-	-
XV хороо	1 210	4 738	1 209	4 736	1	2	-	-
XVI хороо	383	1 084	383	1 084	-	-	-	-
XVII хороо	2 167	7 630	2 167	7 630	-	-	-	-
XVIII хороо	2 694	10 098	2 690	10 087	4	11	-	-
XIX хороо	1 909	7 637	1 899	7 589	10	48	-	-
XX хороо	786	2 495	783	2 482	3	13	-	-
XXII хороо	59	231	59	231	-	-	-	-
XXIV хороо	4 697	15 420	4 697	15 420	-	-	-	-
XXV хороо	2 109	7 286	2 109	7 286	-	-	-	-
XXVI хороо	5 147	18 329	5 147	18 329	-	-	-	-
XXVII хороо	1 489	6 488	1 487	6 475	2	13	-	-
XXVIII хороо	2 039	6 965	1 988	6 723	51	242	-	-
XXIX хороо	2 684	9 192	2 682	9 185	2	7	-	-
XXX хороо	1 766	5 880	1 734	5 746	32	134	-	-
XXXI хороо	1 843	6 160	1 803	6 062	40	98	-	-
XXXII хороо	1 988	7 362	1 987	7 361	1	1	-	-
XXXIII хороо	1 918	6 357	1 909	6 322	9	35	-	-
XXXIV хороо	1 221	4 390	1 220	4 381	1	9	-	-

Хөх-Байшин хороолол
 Ногоон-Гэр хороолол

ГУРАВ. АРГА, АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

Өрхийн сууцны нөхцөл, бүтцийн хангамж тодорхойлох үзүүлэлтэд сууцны төрөл, талбайн хэмжээ, сууцны эзэмшил, халаалтын болон

Ойлголт, тодорхойлолт:

Өрх: Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг ойлгоно. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн холбоотой, хамаатан садан болон гэр бүлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно. Өрх гэдэг нь гэр бүл гэсэн ойлголтоос ялгаатай.

Хүн амын бүртгэл: Тухайн газар нутагт тодорхой цаг хугацааны дотор гарсан хүн ам зүйн үзэгдэл болон хүн амын тоог бүртгэж авах үйл явц болно.

Хүн амын нягтрал: Нэгж газар нутагт ногдох хүн амын тоог илэрхийлнэ. Жишээ нь нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ногдох хүн ам эсвэл тариалах боломжтой нэг хавтгай дөрвөлжин га/км газар нутагт ногдох хүн ам гэх мэт.

$$\begin{aligned} & \text{ХА}_{(\text{няг})} - \text{Хүн амын нягтрал} \\ & \text{ХА}_{(\text{с})} \\ & \text{ХА}_{(\text{няг})} = \frac{\text{ХА}_{(\text{с})}}{\text{НДХ}} \\ & \text{ХА}_{(\text{с})} - \text{Суурин хүн амын тоо} \\ & \text{НДХ} - \text{Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ} \end{aligned}$$

Өрхийн тэргүүн: Өрхийн гишүүд хэнийгээ тэргүүлэгч гэхийг сайн дураар шийдвэрлэнэ. Гэхдээ өрхийн тэргүүлэгч нь өрхдөө байнга оршин суугч, 16-гаас дээш насны бөгөөд өрхийн бусад гишүүд өрхийн тэргүүлэгчээр өргөмжилсөн хүн байна. Хэрвээ өрхийн тэргүүлэгчээ тодорхойлж чадахгүй бол тухайн өрхийн орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа хүнийг өрхийн тэргүүнээр авч үзэж болно.

Өрхийн ам бүлийн гишүүд: Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой болон холбоогүй, нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг хүмүүсийг

цахилгааны эх үүсвэр, усан хангамж, бохир ус, хатуу хог хаягдал зайлуулалтын талаарх үзүүлэлтийг хамааруулна.

тухайн өрхийн ам бүлийн гишүүн гэж үзнэ. Гэхдээ тухайн өрх айлд өрхийн ам бүлийн гишүүдээс нь гадна түүнд хамрахгүй садан төрөл, бусад хүмүүс амьдарч болно. Түүнээс гадна өөр газар амьдарч, ажиллаж (хугацаат цэргийн алба хааж байгаа, өөр аймаг, нийслэлд сурч байгаа оюутан сурагчид, түр хугацаагаар гадаад, дотоодод явагчид гэх мэт) байгаа өрхийн ам бүлийн гишүүд орно.

Өрхийн ам бүлийн дундаж тоо: Нэг өрхөд ногдох өрхөд харьяалагдан амьдардаг хүний тоог илэрхийлнэ.

Сууцны төрөл:

Байшин: Байшин гэж нэг болон олон өрөөтэй, дээвэртэй, гадуураа ханатай, талбай бүхий орон байрыг ойлгоно. Байшинд орон сууцны байшин, бие даасан тохилог сууц (хаус), сууцны тусдаа байшин (гэр хороолын хашаанд барьсан тоосгон, модон, чулуун, шавар ханатай сууцны байшин), нийтийн байр болон нийтийн зориулалтын бусад байр орно.

Нийтийн орон сууц: Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалтай, бүртгэл хийх үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрт зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, бүрэн тоноглол төхөөрөмж, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна. Орон сууцны байшин нь дэд бүтцийн бүх төрлийн суурь хангамжаар тоноглогдсон, дараах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байна. Үүнд:

- Цахилгаан, дулааны шугам сүлжээ болон усан хангамжийн сүлжээтэй
- Сууцны дотор бие засах газартай;
- Сууцны дотор байрлуулсан онгоц, шүршүүртэй;
- Зориулалтын гал тогоо болон хоол хийх талбайтай байна.

Бие даасан тохилог сууц: Бие даасан тохилог сууц (хаус) нь нэг өрх амьдрах зориулалтай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн 24 холболт болон оролт нь бие даасан, дулаан, агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай (ус татдаг) байна. Өрөө тасалгаа нь өөр айлын сууцны өрөө, тасалгааны дээр байрлаагүй, орц, туслах өрөө тасалгаа, дэврийн хөндий, зоорийн давхар, шугам сүлжээний хонгил зэрэг нь нийтийн бус зориулалтай сууцыг үүнд хамааруулна. Сууцны өрөө /унтлагын ба зочны/, гал тогоо, ариун цэврийн буюу шүршүүрийн өрөө, бие засах өрөө, агуулах, ханын шүгээтэй мөн мансардтай болон мансардгүй байж болно.

Сууцны тусдаа байшин: Ихэвчлэн гэр хорооллын хашаанд нэг ба түүнээс олон өрөөтэй, дэд бүтцийн (гал тогоо, онгоц, шүршүүр, халаалтын систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг) хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй сууц орно.

Гэр: Бүх төрлийн монгол гэр болон цаатны урцыг хамааруулна.

Нийтийн байр: Иргэд бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ амьдран суудаг, олон өрөөтэй, бүртгэх үед хүн амьдарч байгаа сууцыг нийтийн байранд хамааруулна. Нийтийн байр нь ихэвчлэн нийтийн гал тогоо, бие засах газар, халуун усны шүршүүр, уулзалтын танхимтай байдаг. Нийтийн байр гэдэгт оюутан, сурагчдын дотуур байр, байгууллагын ажиллагчдын байр, зочид буудал, бусад зориулалтын нийтийн байр орно.

Бусад сууц: Анхнаасаа хүн амьдрах зориулалтаар бариагүй эсвэл хүн амьдрахад зориулан өөрчлөн засаж тохижуулсан сууц багтана. Энэ нь сургууль, үйлдвэр, албан газар, байгууллагын хэсэг буюу өрөө тасалгаанд (зориулалтаараа аж ахуйн нэгж, байгууллага байрлахад зориулагдсан) өрх айл, хүн амьдарч байгаа, мөн байнгын бус, түр орогнох, хүн амьдрахад тохиромжгүй байр, талбайг бусад сууц гэж үзнэ. Жишээлбэл, вагончик, амбаар, пин, агуулах, дэлгүүр, мухлаг, байшингийн дээвэр, хонгил, орц, дулааны шугам сүлжээний худаг (траншей), ой мод, уул хад, агуй зэрэгт өрх айл, хүн амьдарч байгаа бол бусад сууц гэж үзнэ.

